



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



ЭРҮҮЛ МЭНД

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

- Сүрьеэ өвчин үүсгэгч нянгийн онцлогийг илэрхийлсэн хувилбарыг сонгоно уу.
 - Хүчил, шүлтэд тэсвэртэй.
 - Гадаад орчинд амьдрах чадвар сайн.
 - Уураг ихээр агуулдаг.
 - Өөх тос ихээр агуулдаг.
 - Гадаад орчинд амьдрах чадвар сул.

A. 1,3,5 B. 1,2,4 C. 2,3,4 D. 2,4,5
- Сүрьеэ өвчний халдварлах замыг сонгоно уу.

A. ахуйн замаар B. бэлгийн замаар
C. амьсгалын замаар D. хоол хүнсээр
- Улирлын томуугийн эсрэг хийх вакцин нь дархлаажуулалт аль хэлбэр болохыг сонгоно уу.

A. нөхөн хийн дархлаажуулалт
B. нэмэлтээр хийх дархлаажуулалт
C. сайн дурын дархлаажуулалт
D. тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалт
- Уургаар баялаг хүнсийг сонгоно уу.

A. улаан лооль B. гурвалжин будаа
C. наранцэцгийн тос D. загасны мах
- Өсвөрийн тамирчдын хоол хүнснээс авах илчлэгийн хэмжээ насанд хүрэгчдийнхээс их байдгийн шалтгааныг зөв тайлбарласан хувилбарыг сонгоно уу.

A. Бодисын солилцооны эрчим буурдаг тул илчлэг ихтэй хүнс хэрэглэх шаардлагатай.
B. Булчингийн ажил болон биеийн өсөлт хөгжилд илчлэг ихтэй хүнс хэрэглэх шаардлагатай.
C. Хоолны шингэц мууддаг тул илчлэг ихтэй хүнс хэрэглэх шаардлагатай.
D. Зөвхөн булчингийн ажилд энерги зарцуулдаг тул илчлэг ихтэй хүнс хэрэглэх шаардлагатай.
- Чихрийн шижин үүсгэх эрсдэлт хүчин зүйлд хамаарах хувилбарыг сонгоно уу.

A. Идэвхтэй дасгал хөдөлгөөн тогтмол хийх.
B. Зөв зохистой хооллох.
C. Хорт зуршлаас ангид байх.
D. Хэвлийн таргалалт үүсэх.
- Хоол хүнстэй холбоотой өгөгдлүүдийг зөв тодорхойлсон мөрийг сонгоно уу. (үнэн-Ү үсгээр, худал-Х үсгээр тэмдэглэв)

	Ахмад хүмүүсийн бодисын солилцооны эрчим буурдаг.	Эрүүл хооллох тавгийн 30 хувийг үр тариа эзэлнэ.	Тарган хүмүүс л чихрийн шижин өвчинтэй болдог.	Мах махан бүтээгдэхүүн төмрөөр баялаг байдаг.
A	Ү	Х	Х	Ү
B	Х	Ү	Ү	Х
C	Х	Х	Ү	Ү
D	Ү	Ү	Х	Х



**Бусад хүмүүсийн тухай өөрийнхөө бодлыг эргэцүүлэн хариултын
хуудсанд зааврын дагуу бөглөнө үү.**

Доорх зүйлс чамтай хэр тохирч байна вэ?	Би огт тэгдэггүй.	Надтай бага зэрэг адилхан.	Надтай нилээд адилхан.	Би яг тэгдэг.
16. Надад байгаа зүйл хэн нэгэнд байхгүй бол би өрөвддөг.	(A)	(B)	(C)	(D)
17. Хүмүүс яагаад янз бүрийн үйлдэл гаргадаг вэ гэдгийг би сайн ойлгодог.	(A)	(B)	(C)	(D)
18. Хүмүүст хэцүү байгааг хараад би өрөвддөг.	(A)	(B)	(C)	(D)
19. Би бусдад юм хэлэхээсээ өмнө тэрэнд ямар санагдаж байгаа бол гэж боддог.	(A)	(B)	(C)	(D)
20. Миний зөв гэдгийг мэдэж байгаа үед бусдын юу гэх надад хамаагүй.	(A)	(B)	(C)	(D)
21. Би бусдад муухай зүйл хэлэхээсээ өмнө түүнд ямар санагдах бол гэж байнга боддог.	(A)	(B)	(C)	(D)
22. Би бусдын сэтгэл санаа ямар байгаа бол гэдэгт санаа тавьдаг.	(A)	(B)	(C)	(D)
23. Би юмыг олон талаас нь бодож үздэг.	(A)	(B)	(C)	(D)
24. Бусдыг загнаж байгаа хүн муухай харагддаг.	(A)	(B)	(C)	(D)
25. Бусдад хэцүү байгаа ажилд би санаа тавьдаггүй.	(A)	(B)	(C)	(D)